

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2022/2/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866      Цахим хаяг: <a href="mailto:bunchinsuren@audit.gov.mn">bunchinsuren@audit.gov.mn</a>  Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Төлбөрийн акт .....	15
4.1 Аудитын зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР СУМЫН 2 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
С.ШҮРЭНЦЭЦЭГ ТАНАА

№ 2/108

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Урд оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас төлөх төлбөрийн актыг төсвөөс төлсөн
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар арга хэмжээний тухай" тогтоолыг баримталж ажиллалгүй албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон, хүнсний материал нөөцөлж төсөвт төвлөрүүлээгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3 дахь "Улирлын ажлын үр

дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно.” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байдал”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The signature is stylized and appears to be 'B. Mönkhbat'. The stamp is partially obscured by the signature but contains some illegible text.

Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,511,255.51</b>	<b>60,454,866.73</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	197,148.78	13,870.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	197,148.78	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	13,870.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	13,870.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	45,314,106.73	60,440,996.73
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	36,312,956.73	47,233,708.73
35110	Тусгай зориулалттай материал	34,765,056.73	42,388,318.73
35130	Эм боох материал	1,547,900.00	4,845,390.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,001,150.00	13,207,288.00
35410	Бичиг хэргийн материал	250,000.00	883,200.00
35420	Аж ахуйн материал	2,354,950.00	5,284,900.00
35450	Барилгын засварын материал	1,950,000.00	00.00
35460	Хүнсний материал	777,150.00	3,370,138.00
35470	Бусад хангамжийн материал	3,669,050.00	3,669,050.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>525,946,116.40</b>	<b>532,265,453.90</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	525,946,116.40	532,265,453.90
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	408,346,116.40	414,665,453.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	403,518,667.00	403,518,667.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,947,179.67	-29,527,329.63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,521,835.00	43,696,330.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,677,542.96	-24,797,948.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,875,265.80	14,743,701.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,295,057.45	-5,312,543.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,233,967.00	23,205,023.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,576,372.00	-13,983,479.28
39217	Ном	2,692,533.68	3,123,033.68
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	117,600,000.00	117,600,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	117,600,000.00	117,600,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>571,457,371.91</b>	<b>592,720,320.63</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>635,550.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	635,550.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	635,550.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	635,550.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>571,457,371.91</b>	<b>592,084,770.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	571,457,371.91	592,084,770.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181,448,936.00	181,448,936.00
51101	Өмч: - төрийн	181,448,936.00	181,448,936.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-8,863,250.39	11,974,448.33
51210	Өмнөх үеийн үр дүн	-8,863,250.39	-8,652,950.39
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	20,627,398.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398,871,686.30	398,661,386.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>571,457,371.91</b>	<b>592,720,320.63</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>379,482,512.00</b>	<b>433,460,750.94</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,388,500.00</b>	<b>16,264,593.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,388,500.00	16,264,593.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,388,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,388,500.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	00.00	8,021,331.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал		8,243,262.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>64,616,412.00</b>	<b>76,452,557.94</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,477,600.00	340,743,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>21,452,812.00</b>	<b>35,934,658.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,452,812.00	35,934,658.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>43,163,600.00</b>	<b>40,517,899.94</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,163,600.00	40,517,899.94
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>387,690,331.08</b>	<b>412,833,352.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>387,690,331.08</b>	<b>412,833,352.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>361,835,113.68</b>	<b>375,645,774.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>233,221,908.02</b>	<b>257,184,222.17</b>
210101	Үндсэн цалин	175,215,508.02	193,397,838.96
210102	Нэмэгдэл	43,367,300.00	47,293,800.00
210104	Урамшуулал	14,639,100.00	16,492,583.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,691,600.00</b>	<b>33,958,959.82</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,093,196.02	24,544,575.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,371,417.00	2,301,179.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,876,976.00	2,068,653.00
210204	Ажилгүйдлийн даатгал	401,661.00	611,741.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,948,349.98	4,432,811.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,884,944.36</b>	<b>36,517,899.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,509,584.36	1,917,452.94
210302	Түлш, халаалт	25,236,144.00	25,508,431.00
210303	Цэвэр, бохир ус	10,139,216.00	9,092,016.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,094,404.00</b>	<b>7,034,867.00</b>
210401	Бичиг хэрэг	399,000.00	613,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,503,721.50	2,999,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,364,832.50	1,360,267.00
210404	Ном, хэвлэл	18,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	665,900.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,142,950.00	1,881,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,254,868.45</b>	<b>15,317,632.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,221,570.00	2,826,350.00
210502	Хоол, хүнс	27,943,898.45	12,212,782.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,089,400.00	278,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,817,731.00</b>	<b>8,108,000.00</b>
210604	Урсгал засвар	7,817,731.00	8,108,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>112,000.00</b>	<b>106,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	112,000.00	106,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>889,700.00</b>	<b>1,214,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	889,700.00	624,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,867,957.85</b>	<b>16,203,493.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,668,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,040,130.00	1,732,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,827,827.85	12,802,393.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,855,217.40</b>	<b>37,187,577.79</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,530,812.00</b>	<b>36,039,687.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,816,612.00	31,022,087.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,200.00	4,912,570.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,000.00	105,030.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>328,655.64</b>	<b>01.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	278,655.64	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,995,749.76</b>	<b>1,147,889.79</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,995,749.76	1,147,889.79
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-8,207,819.08</b>	<b>20,627,398.72</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-8,207,819.08</b>	<b>20,627,398.72</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>374,094,012.00</b>	<b>417,196,157.94</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>374,094,012.00</b>	<b>417,196,157.94</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,477,600.00	340,743,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>21,452,812.00</b>	<b>35,934,658.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,452,812.00	35,934,658.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>43,163,600.00</b>	<b>40,517,899.94</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,163,600.00	40,517,899.94
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>369,567,712.00</b>	<b>406,095,757.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>369,567,712.00</b>	<b>406,095,757.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>343,712,494.60</b>	<b>368,896,510.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>233,124,759.24</b>	<b>254,354,583.21</b>
210101	Үндсэн цалин	175,118,359.24	190,568,200.00
210102	Нэмэгдэл	43,367,300.00	47,293,800.00
210104	Урамшуулал	14,639,100.00	16,492,583.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,691,600.00</b>	<b>35,955,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,190,300.00	26,399,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,375,300.00	2,388,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,900,300.00	1,911,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	475,100.00	477,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,750,600.00	4,778,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,884,944.36</b>	<b>36,517,899.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,509,584.36	1,917,452.94
210302	Түлш, халаалт	25,236,144.00	25,508,431.00
210303	Цэвэр, бохир ус	10,139,216.00	9,092,016.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,035,633.00</b>	<b>9,315,517.00</b>
210401	Бичиг хэрэг	110,700.00	1,005,000.00
210402	Тээвэр, шатахуун	598,300.00	2,999,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,364,833.00	1,360,267.00
210404	Ном, хэвлэл	18,000.00	35,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	665,900.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,277,900.00	3,735,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,792,977.00</b>	<b>19,673,510.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,043,400.00	3,804,040.00
210502	Хоол, хүнс	23,303,177.00	14,846,270.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	446,400.00	1,023,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,195,501.00</b>	<b>6,160,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	0.00
210602	Тавилга	00.00	0.00
210604	Урсгал засвар	6,195,501.00	6,160,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>112,000.00</b>	<b>106,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	112,000.00	106,000.00

**Баянхонгор бүсийн 2 дугаар дэвсгэрийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>889,700.00</b>	<b>1,214,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	589,700.00	624,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,985,380.00</b>	<b>5,598,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	3,795,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,785,380.00	1,803,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,855,217.40</b>	<b>37,199,247.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,530,812.00</b>	<b>36,051,357.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,816,612.00	31,022,087.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,200.00	4,912,570.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,000.00	116,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>328,655.64</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	278,655.64	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,995,749.76</b>	<b>1,147,889.79</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,995,749.76	1,147,889.79
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>4,526,300.00</b>	<b>11,100,400.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>4,526,300.00</b>	<b>11,100,400.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,526,300.00</b>	<b>11,100,400.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	4,526,300.00	11,100,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,526,300.00	11,100,400.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-4,526,300.00</b>	<b>-11,100,400.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-897,741.21	579,428,881.09
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,965,508.18	-7,965,508.18
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-8,863,250.39	571,463,371.91
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-8,863,250.39	571,463,371.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			210,300.00	210,300.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-8,662,950.39	571,673,671.91
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-210,300.00	00.00	-210,300.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	20,627,398.72	20,627,398.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,448,936.00	398,667,386.30	11,974,448.33	592,090,770.63

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	381,261,500.00	380,113,610.15	1,147,889.8	99.7
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	381,261,500.00	380,113,610.15	1,147,889.8	99.7
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	381,144,800.00	379,996,910.15	1,147,889.8	99.7
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	254,436,300.00	254,354,583.21	81,716.8	100.0
210101	Үндсэн цалин	190,568,200.00	190,568,200.00	0.0	100.0
210102	Нэмэгдэл	47,293,800.00	47,293,800.00	0.0	100.0
210104	Урамшуулал	16,574,300.00	16,492,583.21	81,716.8	99.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,956,300.00	35,955,900.00	400.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	26,399,000.00	26,399,000.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,389,300.00	2,388,900.00	400.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,911,500.00	1,911,500.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	477,800.00	477,800.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,778,700.00	4,778,700.00	0.0	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,517,900.00	36,517,899.94	0.1	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,999,000.00	1,917,452.94	1,081,547.1	63.9
210302	Түлш, халаалт	23,672,900.00	25,508,431.00	-1,835,531.0	107.8
210303	Цэвэр, бохир ус	9,846,000.00	9,092,016.00	753,984.0	92.3
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,733,900.00	9,615,517.00	118,383.0	98.8
210401	Бичиг хэрэг	1,005,000.00	1,005,000.00	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,999,400.00	600.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,392,400.00	1,360,267.00	32,133.0	97.7
210404	Ном, хэвлэл	358,400.00	335,000.00	23,400.0	93.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	180,000.00	20,000.0	90.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,778,100.00	3,735,850.00	42,250.0	98.9
2105	<b>Нормативт зардал</b>	20,544,100.00	19,673,510.00	870,590.0	95.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,804,500.00	3,804,040.00	460.0	100.0
210502	Хоол, хүнс	15,716,300.00	14,846,270.00	870,030.0	94.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,023,300.00	1,023,200.00	100.0	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,899,000.00	16,830,100.00	68,900.0	99.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,949,900.00	50,100.0	99.5
210602	Тавилга	720,000.00	720,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	6,179,000.00	6,160,200.00	18,800.0	99.7
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	108,900.00	106,000.00	2,900.0	97.3
210702	Дотоод албан томиллолт	108,900.00	106,000.00	2,900.0	97.3
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,214,700.00	1,214,700.00	0.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	624,700.00	624,700.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.0	100.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5733700.00	5728700.00	5,000.0	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	3,795,000.00	5,000.0	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,933,700.00	1,933,700.00	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116700.00	116700.00	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	116,700.00	116,700.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	116,700.00	116,700.00	0.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	381,261,500.00	380,113,610.15	1,147,889.9	99.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	340,743,600.00	339,595,710.21	1,147,889.8	99.7
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	340,743,600.00	339,595,710.21	1,147,889.8	99.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,517,900.00	40,517,899.94	0.1	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	40,517,900.00	40,517,899.94	0.1	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9	9	0.0	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	155	155	0.0	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	155	155	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21	0.0	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	12	12	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,402,612.00</b>	<b>35,934,657.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,402,612.00	35,934,657.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,402,612.00	35934657.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,402,612.00	35,934,657.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,816,612.00	31,022,087.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,000.00	4,912,570.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>21,402,812.00</b>	<b>35934657.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,402,812.00	35934657.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,402,812.00	35,934,657.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 20 өдрийн 08 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч С.Шүрэнцэцэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Бүрэнжаргал нар зурж байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Баянхонгор сумын 2 дугар цэцэрлэг нь зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж хүүхэд бүрийн эрүүл мэнд болон хөгжлийн онцлог хэрэгцээнд тулгуурлан сурах үйлийг дэмжиж цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй зохион байгуулна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 387,448.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,811.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,068.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,334.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,62.9 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,511.3</b>	<b>60,454.9</b>	<b>14,943.6</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	197.1	13.9	(183.3)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	45,314.1	60,441.0	15,126.9
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>525,952.1</b>	<b>532,271.5</b>	<b>6,319.3</b>
Үндсэн хөрөнгө	587,992.3	606,436.8	18,444.5
Хуримтлагдсан элэгдэл	(62,040.2)	(74,165.3)	(12,125.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>571,463.4</b>	<b>592,726.3</b>	<b>21,262.9</b>
Өр төлбөр	-	635.6	635.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	571,463.4	592,090.8	20,627.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>571,463.4</b>	<b>592,726.3</b>	<b>21,262.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 60,441.0 мянган төгрөг болж 15,126.9 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны яамнаас 7,623.3 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом болон сургалтын хэрэглэгдэхүүн, Баянхонгор сумын ЗДТГ-аас 510.0 мянган төгрөгийн оношлуур, халуун хэмжигч бусад эм боох материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан ба төсвийн хөрөнгөөр эм боох материал болон аж ахуйн материал авч нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 606,436.8 мянган төгрөг болж 18,444.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11,100.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 8,021.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай тус тус холбоотой байна.

Ажиллагсадтай холбоотой өглөгийн данс 635.5 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тус байгууллагын ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалыг нөхөн төлөхөөр акт тогтоосонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 592,090.8 мянган төгрөг болж 20,627.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 20,627.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 573,448.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 573,448.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 185,261.3 мянган төгрөгөөр бууруулж 388,187. 2 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 381,261.5 мянган төгрөг болгож 6,925.7 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 381,261.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 340,743.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 40,517.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 339,595.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 40,517.9 санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 380,113.6 мянган төгрөгийг зарцуулж 1,147.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 380,113.6 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх НДШ-ээс 81.7 мянга, хангамж бараа материалын зардлаас 118.4 мянга, хоолны зардлаас 870.0 мянга, эд хогшил авах зардлаас 68.9 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 31,022.1 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 4,912.6 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж нийт 6 сартай тэнцэх хэмжээний тэтгэмж болон тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмж нийт 35,934.7 мянган төгрөгийн зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 97 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 412,833.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 25,143.0 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, тээвэр шатахууны зардал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл авах зардал, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал тус тус нэмэгдсэн, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, хоол, хичээл практикийн зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 396,398.1 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 148 мэдээллийг хугацаанд нь байршуулж 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 зарлагын 31022.1 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлбэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	93	3	
	Нийт	27	151	146	3	2

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Тайлант онд нийт 381,261.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 380,113.5 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 1,147.9 мянган төгрөг буюу төсвийн 0.3 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Тайланд онд тус цэцэрлэгийн үйлчлэгч Д.Бадамгарав 2021 оны 9 сард өндөр настны тэтгэвэрт гарсан ба ажлын зайлшгүй шаардлагын улмаас .... дугаар тушаалаар ажилтан томилсон, жижүүр Э.Цэрэнлхагва 2021 оны 12 сард тэтгэвэрт гарсан оронд нь ажилтан томилоогүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 41,663.6 мянган төгрөгөөр, тодотголоор 5,145.7 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 36517.9 мянган зарцуулж анх баталсан дүнгээс 5,145.7 мянган төгрөг буюу 12.3 хувь хэмнэсэн ч Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зорим арга хэмжээний тухай" тогтоолын 1.8 дахь заалтаар 20 -оос доошгүй хувийг хэмнэх гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй ба түлш халаалтын зардлаас 1,500.0 мянга зориулалт бусаар зарцуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10,360.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2021.04.29-ны 15 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 44,225.9 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 2829.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулж 6,168.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 35,228.2 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд 258,581.4 мянган төгрөгийн цалингийн зардал гарсан ба санхүүгийн үр дүнгийн тайланд 255,751.8 мянган төгрөгөөр буюу 2,829.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байгаа нь Сангийн сайдын 388 дугаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3.2-т "Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын данстуудад хуримтлуулан

бүртгэнэ”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг нэмэгдүүлж, НДШ-ийн зардлын дансыг бууруулж залруулав.

#### **4.2 Төлбөрийн акт**

1.2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар халаалтын үйлчилгээ үзүүлдэг “Зүүн шанд” ХХК-д 2020 оны 8 дугаар сард гэрээний үнийн дүнгээс 1,500.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн зөрчил илэрч халаалт нийлүүлэгч Зүүн шанд ХХК-аас суутган тооцож барагдуулах төлбөрийн акт тогтоосон байхад уг төлбөрийг 2021.04.21-ний өдөр халаалтын зардлын төсвөөс төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх оны төлбөрийн актыг төсвөөс төлж Төрийн аудитын байгууллагаас өгсөн шаардлагыг биелээгүй тул байгууллагын дарга, нягтлан бодогч нараар халаалтын зардлын 1,500.0 мянган төгрөгийг -төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. БСШУЯ-аас 13,369.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшил тээвэрлэж ирэх зардалд жолооч Г.Мөнхдөлтэй гэрээ байгуулаагүй төсвөөс 2021.11.30-нд 2017.0 мянган төгрөг тээврийн хөлсөнд төлсөн, ХАОАТ-ын 201.7 мянган төгрөгийг суутгаагүй, анхан шатны е-баримт байхгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажил гүйцэтгэсэн гэрээний тээврийн зардалд ногдох ХАОАТ-ын 201.7 төгрөгийг Г.Мөнхдөлөөр буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2021.04.16-ны өдрийн Б/12, Б/13 дугаар тушаалаар нэр бүхий 7 багш ажиллагсдад сахилгын шийтгэл оногдуулсан байхад 2021.12.11-ны өдрийн Б/36 дугаар тушаалаар 1939.1 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргаж олгосон. Мөн үр дүнгийн урамшуулал улирал бүр олгосон байхад 12 дугаар сард ажиллагсдад жилийн үр дүнгийн урамшуулалт цалин 2,527.3 төгрөгийг эрхлэгч тушаал гарган олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.3 дахь “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно.” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын сахилгын шийтгэлтэй ажилтнуудад олгосон үр дүнгийн урамшуулал болон цалингийн нийт 4,466.4 мянган төгрөгийг нэр бүхий албан хаагчдаас суутган тооцож төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### **4.3 Аудитын зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээллээс тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 3 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 мөнгөн гүйлгээний 31,022.1 мянган төгрөгийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 3 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

2. Тайлант онд нийт 381,261.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 380,113.5 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 1,147.9 мянган төгрөг буюу төсвийн 0.3 хувийг буцаан төвлөрүүлсэн, байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 26,090.4 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 25078.4 мянга буюу 1012.0 мянган төгрөг хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8<sup>1</sup> дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол болон журмыг хэрэгжүүлэн ажиллах. Мөн цалингийн сангаас үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгохыг таслан зогсоох

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/									
				Үүнээс									
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Баянхонгор сумын дугаар цэцэрлэг	2		6	44,225.9	1	2,829.6	3	6,168.1	0	0	2	35,228.2

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_